



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/405

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 8 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өндрөөс аврах ажиллагаа зохион байгуулах заавар”-ыг нэгдүгээр, “Өндрөөс болон нисдэг тэргээр аврах ажиллагаа зохион байгуулах үеийн биет дохио”-г хоёрдугаар, “Өндрөөс нэрвэгдэгч болон хүнийг буулгах дараалал”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан зааврыг мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажиллагааны удирдлагын газар (хурандаа Б.Баянмөнх)-т даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН



ӨНДРӨӨС АВРАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Өндрөөс аврах ажиллагаа зохион байгуулах, алба хаагчдыг шуурхай удирдлагаар хангах, голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү зааврын зорилго оршино.
- 1.2. Энэхүү зааврыг эрэн хайх, аврах болон гал түймэртэй тэмцэх нэгж дагаж мөрдөнө.
- 1.3. Энэхүү зааварт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. "өндөр барилга, байгууламж" гэж хүний амь насанд эрсдэл учруулахуйц өндөртэй барилга, цамхагт кран, үйлдвэрийн яндан, автозамын гүүр, өндөр хүчдэлийн баганыг;
 - 1.3.2. "хаяг" гэж дуудлага өгсөн газрын байршлыг;
 - 1.3.3. "ярилцлага" гэж өндрөөс үсрэх оролдлого хийж буй иргэнийг тайвшруулах, анхаарлыг сарниулах, татгалзуулахаар хийж буй сэтгэл зүйн хэлцлийг;
 - 1.3.4. "винчмэн" гэж нисдэг тэргийг аврах ажиллагаанд хөөрөхийн өмнө өргөгч төхөөрөмжтэй ажиллаж буй инженерийг.

Хоёр. Ажиллагааны зохион байгуулалт

- 2.1. Өндрөөс аврах ажиллагааг дараах тусгай зориулалтын техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан зохион байгуулна. Үүнд:
 - Аврагч, аврах олс, дамнуурга;
 - Аврах хоолой;
 - Автомеханик шат;
 - Нисдэг тэрэг;
 - Авто өргөгч;
 - Аврах тавцан.
- 2.2. Аврах олс болон дамнуурга ашиглан өндөр барилга байгууламжаас хүн болон нэрвэгдэгчийг буулгах ажиллагааны үед Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/330 дугаар тушаалаар баталсан "Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам"-ыг мөрдлөг болгоно.
- 2.3. Аврагч, аврах олс, дамнуурга, аврах хоолой, автомеханик шат зэргийн тусламжтайгаар аврах ажиллагааг зохион байгуулах боломжгүй болсон тохиолдолд бүлгийн дарга, харьяа нэгжийн анги, салбарын захирагчид илтгэн нисдэг тэргээр аврах ажиллагааг зохион байгуулна.
- 2.4. Агаараас эрэн хайх, аврах ангийн захирагчтай зөвшилцөж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга эсхүл тэргүүн дэд даргын зөвшөөрлөөр нисдэг тэргийг ажиллагаанд хөөргөнө.
- 2.5. Тухайн барилгад гал түймэр гарч хүн барилгын тагтан дээр байрлаж байгаа тохиолдолд нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомеханик шат болон аврах хоолойг ашиглана.
- 2.6. Бүлгийн дарга хаягт хүрэх хамгийн дөт маршрутыг тодорхойлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүргийг аврагч-жолооч, холбоочинд өгч замын хөдөлгөөний ачааллыг дуудлага хүлээн авагчид мэдээлнэ.
- 2.7. Аврагч-холбоочин (цаашид "дуудлага хүлээн авагч" гэх) өндөр барилга, байгууламжаас аврах ажиллагааны талаарх дуудлагын мэдээллийг хүлээн авсан даруйд дуудлагын хуудсыг бүлгийн дарга-аврах ажиллагааны зааварлагч ("цаашид бүлгийн дарга" гэх)-д өгнө.

2.8. Шаардлагатай тохиолдолд замын хөдөлгөөний удирдлагын төвтэй холбогдож, хөдөлгөөний ачаалал ихэссэн хэсгүүдэд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зохицуулалт хийлгэнэ.

2.9. Аврах бүлэг хаягт очсон хугацааг аврагч-жолооч, холбоочин дуудлага хүлээн авагчид мэдээлэх ба аврах ажиллагааг удирдах бүлгийн дарга цагийн байдлыг үнэлж, ажиллагааг эхлүүлнэ.

2.10. Аврах бүлэг хаягт очихдоо өндрөөс үсрэх оролдлого хийж буй иргэний анхаарлыг татахгүйн тулд дуут дохиог унтраах, тухайн иргэний байршлын эсрэг талаас очих арга хэмжээ авна.

2.11. Бүлгийн дарга боломжит эх сурвалжаас өндөр барилга, байгууламжид байрлаж байгаа иргэний байршлын мэдээллийг авч, тухайн объектын орц, гарц, схем зураглалыг судалж ажиллагаа явуулахад саад болохуйц нөхцөл байдлыг нэн даруй үнэлнэ.

2.12. Өндрөөс аврах ажиллагааны дуудлагаар үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан "Эмч-сэтгэл зүйч"-ийг ажиллуулна.

Гурав. Аврах ажиллагаа

3.1. Өндрөөс аврах ажиллагаа эхлүүлэхэд дараах арга хэмжээг авна. Үүнд:

3.1.1. Аврах бүлэг шаардлагатай багаж хэрэгслийг авч объектын байрлал руу хөдөлгөөн үйлдэнэ.

3.1.2. Бүлгийн дарга аврах ажиллагааг хяналтад авч, удирдан чиглүүлэх, биет дохио өгөх боломжит байршлыг эзэлж ажиллагааг удирдана.

3.1.3. Хаягт түрүүлэн ирсэн цагдаагийн алба хаагчтай хамтын (ярилцлага хийх, аврах ажиллагааны бүсэд энгийн иргэдийг нэвтрүүлэхгүй байх, ямар нэгэн дүрс бичлэг хийх зэргээр аврах ажиллагаанд саад учруулахгүй байх, аврах тавцан дэлгэх талбайг чөлөөлөх зэрэг) ажиллагааг тодотгоно.

3.1.4. Аврах ажиллагаа зохион байгуулах барилга, байгууламжийн шаардлагатай хийцийг тодорхойлж хамгаалалтын бэхэлгээ хийнэ.

3.1.5. Бүлгийн даргын заавраар аврагчид хуваарьт байрлалаа эзэлж цагдаагийн алба хаагч тухайн иргэнтэй ярилцлага эхлүүлээгүй тохиолдолд томилгоот аврагч ярилцлагыг эхлүүлнэ. Энэ үед аврагчийн хамгаалалтын бэхэлгээг бэлэн болгосон байна.

3.1.6. Бүлгийн дарга өндөрт байгаа аврагчтай хэт богино долгионы гар станц болон биет дохиогоор харилцаж ажиллагааг удирдана.

3.1.7. Аврах ажиллагаа эхэлснээс хойш хаагчид гар утасны дууг хаах бөгөөд ямарваа гаднын дуудлага хийх болон хариу өгөхийг хориглоно.

3.1.8. Аврах ажиллагааны талаарх бодит мэдээллийг зөвхөн аврагч, жолооч-холбоочноор дамжуулан дуудлага хүлээн авагчид өгнө.

3.1.9. Хүн байрлалаа өөрчлөх хөдөлгөөн үйлдсэн тохиолдолд түүний чигийн дагуу аврах тавцанг зөвөөрлөх арга хэмжээг удирдагчийн үүргийн дагуу авна. Удирдагч аврах тавцан зөвөөрлөх чиглэлийг хариуцсан аврагчийн нүүр хандсан объектын дагуу (баруун, зүүн гар тийш) өгнө.

3.1.10. Хэрвээ өндөрт 2 буюу түүнээс дээш иргэн байгаа тохиолдолд хүн тус бүрт аврах дайрагчийг бэлэн болгоно. Аврах дайралт хийхэд аюултай нөхцөлд дайралтыг түр зогсоож, нэмэлтээр Үндэсний аврах бригадаас бүлгийг дуудна.

3.1.11. Өндөрт байгаа хүний байрлалын харалдаа аврах тавцанг бэлтгэж хашлага, хашаа, автомашин зэргийг холдуулах ажлыг цагдаагийн алба хаагчтай хамтран зохион байгуулна.

3.1.12. Хүн өндрөөс үсрэх үйлдлийг хийх нь илт мэдэгдсэн тохиолдолд аврагч түүний анхаарлыг түр сарниулах (ярилцах) арга хэмжээ авч, аврах дайралтыг аврагч бүлгийн даргын шийдвэрээр гүйцэтгэнэ.

3.1.13. Өндрөөс үсрэх дуудлагаар аврагчийн биед аюул занал учруулахаар мэс болон галт зэвсэгтэй нь тогтоогдвол цагдаагийн байгууллагын бүлгийг ажиллуулна.

3.1.14. Өндрөөс аврах ажиллагаа зохион байгуулах үед шаардлагатай тохиолдолд аврах ажиллагааны удирдагчийн шийдвэрээр хүн, хуулийн этгээдийн өрөө, тасалгааг ашиглаж болно.

Дөрөв. Автомеханик шаттай аврах ажиллагаа

4.1. Автомеханик шатны автомашиныг (цаашид автомеханик шат гэх) 3-с доошгүй жил ажилласан сагстай өргөгчийн операторын сургалтад суусан алба хаагчийг томилно.

4.2. Автомеханик шат байрлуулах талбай нь хатуу хучилттай 6 градусаас ихгүй налуу байна.

4.3. Автомеханик шатыг өгөгдсөн цэгт зөвшөөрөгдсөн өнцгөөр цонх, тагт, дээвэр зэрэгт чиглүүлэн сунгаж, налуулж болохоор зайд байрлуулж ажиллуулна.

4.4. Автомеханик шатыг цахилгаан гүйдлийн болон радио, холбооны шугамд хүргэхээргүйгээр сунгана.

4.5. Барилгын хэсэгт сунган байрлуулсан автомеханик шатаар буух, өгсөх гал сөнөөгчдийн хоорондын зай 3 метрээс багагүй байна.

4.6. Хэрэв шатаа барилгын хэсэгт тулгаагүй хөндий, 60 хэмээс ихгүй налуу өнцөгтэй байрлуулсан бол зөвхөн нэг гал сөнөөгч ажиллана. Харин шатны сунгалтын налуу өнцөг нь 60-75 хэм байвал шатан дээр 10 метрийн зайтай хоёр аврагч, 75-80 хэм налуу өнцөгтэй сунгасан үед 5 метрийн зайтай гурван аврагч ажиллана.

4.7. Автомеханик шатыг үйлдвэрээс тогтоосон аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан эргэлтийн хурдыг тохируулж ажиллуулна.

4.8. Автомеханик шатыг сунгах үед шат тэгшлэлтийн автоматыг салгах, шатыг сунгасан нөхцөлд автомашиныг байрнаас нь хөдөлгөхийг хориглоно.

4.9. Шатыг гар ажиллагаагаар сунгахад шатны сунгалтын урт, налуугийн өнцгийг зохих заалтын дагуу байнга хянаана.

4.10. Шатыг сунгахын өмнө дөрвөн тулгуурыг заавал буулгасан байх шаардлагатай.

4.11. Автомеханик шатыг хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгтэй ойр сунгах, ажиллуулах тохиолдолд доорх хүснэгтэд тогтоосон аюулгүй зайн хэмжээ баримтална.

(Эрчим хүчний сайдын 2014 оны 101 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтын 1 дүгээр хүснэгт)

Хүчдэл (кВ)		Ажилтан ба тэдний хэрэглэж байгаа багаж хэрэгсэл, түр хаалт хашилт хүртэл зай (м)	Автомашин, ачаа өргөх кран, оосорлох хэрэгсэл ба ачааны ойртож болох зай (м)
1кВ хүртэл	Агаарын шугамд	0.6	1.0
	Бусад цахилгаан байгууламжид	Норм тогтоохгүй, хүрч шүргэж болохгүй	1.0
1-35 кВ		0.6	1.0
60*; 110 кВ		1.0	1.5
220 кВ		2.0	2.5
330 кВ		2.5	3.5
400*; 500 кВ		3.5	4.5
*-тогтмол гүйдэл			

Тав. Нисдэг тэргээр аврах ажиллагаа

5.1. Нисэх баг, инженер техникийн бүрэлдэхүүн нислэгийн аюулгүй байдлыг нисэхийн дүрмийн дагуу хариуцан ажиллана.

5.2. Нисдэг тэргийг аврах ажиллагаанд хөөрөхийн өмнө өргөгч төхөөрөмжтэй ажиллаж буй инженер (цаашид "винчмэн" гэх)-ийн дохиогоор агаарын хөлөгт аврах ажиллагааны мэргэжилтэн, аврагч, эмч, сувилагч (цаашид "аврах багийн гишүүн" гэх) нар хамгаалалтын холбогчийг холбож онгоцонд жингийн тэнцвэрийг алдуулалгүйгээр жигд хуваарилан сууна.

5.3. Аврах ажиллагаа явагдах голомтод нисдэг тэрэг очиж орчны аюулгүй байдлыг үнэлэх зорилгоор хяналтын тойргийг хийж гүйцэтгэнэ.

5.4. Нисдэг тэрэг ашиглан аврах ажиллагаа явуулах нөхцөлд тухайн барилга байгууламжийн хийсэх эрсдэлтэй эд зүйлс, орчны нөхцөл байдлыг үнэлэх ажиллагаа хийгдэнэ.

5.5. Нисдэг тэрэг ашиглан аврах ажиллагаа явуулах үед нэрвэгдэгч болон хүн дээр нисдэг тэрэг ирж нисгэгч ажиллагааг эхлүүлж болно гэсэн нөхцөлд аврах ажиллагааг эхлүүлнэ.

5.6. Аврах багийн гишүүн аврах ажиллагааны үед нисдэг тэрэгнээс гарах үед зөвхөн винчмэний дохиогоор ажиллана.

5.7. Аврах багийн гишүүдийг винчмэн өргөгч төхөөрөмжийн дэгээтэй холбож дараагийн дохиог өгнө.

5.8. Аврах ажиллагааны мэргэжилтэн ослын голомтод нисдэг тэрэгнээс эхэнд бууж аюулгүйн бүсийг тогтоон, цагийн байдлыг үнэлж шаардлагатай аврах багийн гишүүн, багаж, хэрэгслийг тодотгон нисэх багтай холбоонд орно.

5.9. Винчмэн дохио өгөх үед аврах багийн гишүүд нисдэг тэрэгний гадна талд гарч чарга дээр зогсож бэхэлгээнүүдийг нэг бүрчлэн шалгана.

5.10. Аврах багийн гишүүн доош буух үед зөвхөн газардах талбайгаа харах ба хөл газарт хүрэхээс 2 метр өндөрт хоёр гарыг мөрний түвшинд алдлан дохио өгөхөд винчмэн доошлох хурдыг багасгана. Үүний дараа аврах багийн гишүүн доош харан газардахад бэлдэнэ.

5.11. Хөл газарт хүрч аврах багийн гишүүн аюулгүй болсон нөхцөлд дэгээг салгаж винчмэнд троссыг дээш өргөх дохиог өгнө.

5.12. Нэрвэгдэгч болон хүн дээр аврах багийн гишүүн очсон нөхцөлд зөвхөн аврах багийн гишүүний дохиогоор дараагийн заавар (нисдэг тэрэг рүү татан оруулах, холболт шалгах, ... гэх мэт)-ийг винчмэн гүйцэтгэнэ.

5.13. Аврах багийн гишүүн дээш өргүүлэх үед холболтыг хийж өргөх дохиог винчмэнд харагдахаар өгнө.

5.14. Газраас 2 метр өндөрт ирмэгц аврах багийн гишүүн 2 гарыг мөрний түвшинд алдлан зогсоох дохиог өгч ахин холболтуудыг шалгасны дараа өргөх дохиог винчмэнд өгнө. Хэрэв холболт болон өргөхөд аюултай гэж үзвэл гарыг доош унжуулж тойрог хэлбэр үзүүлэн буцаж буулгах дохиог өгнө.

5.15. Аврах багийн гишүүн нисдэг тэргэнд ойртох үед нисдэг тэрэгний эд ангид цохигдохоос болгоомжилно.

5.16. Аврагч нисдэг тэрэгний хаалганд ирэх үед винчмэн бүхээгийн бэхэлгээг аврагчид холбон нисдэг тэрэг рүү орох дохио өгнө.

5.17. Аврагч бүхээгт орсон үед зөвхөн винчмэний дохиогоор дараагийн үйлдлүүдийг хийнэ.

5.18. Дамнуургатай ажиллах үед нисдэг тэрэгний ирэх чиглэлийн дагуу нэрвэгдэгчийн толгой хэсгийг харуулсан байна. Чиглүүлэгч олс болон агаарын чиглүүлэгчийг дамнуургатай бэхэлсэн эсэхийг сайтар шалгана.

5.19. Дамнуурга өргөх явцад аврах ажиллагааны мэргэжилтэн чиглүүлэгч олсыг нисдэг тэрэгний 13 цагийн (нисгэгчид харагдах) зүгт зогсож барина. Нисдэг тэрэгний хаалганд дамнуургатай аврагч очиж винчмэн аюулгүйн холболтыг хийж, чиглүүлэгч олсыг дамнуургаас салгах хүртэл аврах багийн гишүүн газраас удирдана.

5.20. Дамнуургыг нисдэг тэргэнд оруулах үед нисдэг тэрэгний их биед цохихоос хамгаалан оруулна.

Зургаа. Аврах хоолой

6.1. Аврах хоолойг түүний ажиллах зарчим, буулгах аргачлалыг судалж дадлага сургалтаар чадвар эзэмшсэн алба хаагч ажиллуулна.

6.2. Аврах хоолойг ашиглахдаа дараах шаардлагыг дагаж мөрдөнө. Үүнд:

6.2.1. Буулгахын өмнө аврагч олсны тусламжтайгаар буух хоолойн ажиллагааг шалгаж хэвийн эсэхийг нягтална.

6.2.2. Аврах хоолой байрлуулсан газрын ойр орчим цахилгааны эрсдэл байгаа эсэхийг шалгана.

6.2.3. Аюулгүй байдлын үүднээс бууж буй иргэн аврах хоолойд гэмтэл учруулж болзошгүй тул хурц үзүүртэй зүйл биед байхыг хориглоно.

Долоо. Албан тушаалтны нийтлэг үүрэг

7.1. Бүлгийн дарга (аврах ажиллагааны удирдагч)-ын үүрэг:

7.1.1. Аврах ажиллагааны аюулгүй бүсийг тогтоон цагийн байдлыг үнэлж, аврах ажиллагааг шуурхай эхлүүлнэ.

7.1.2. Цагдаагийн алба хаагчтай хамтран тогтоосон аврах ажиллагааны бүсийг хамгаалалтад авхуулж, автомашины хөдөлгөөнд хяналт тавиулна.

7.1.3. Аврагчдыг томилгоожуулж, аюулгүй байдалд хяналт тавин аврах ажиллагааг удирдан зохион байгуулах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

7.1.4. Томилогдсон аврагч нарт холбооны хэрэгслээс гадна нэмэлт мэдээллийн биет дохиог өгнө.

7.1.5. Иргэний байршил, тэдгээрийн тоо, богино очих зам, чиглэл, биеийн байдал, иргэнд нөлөөлөх аюултай хүчин зүйлс байгаа эсэхийг тодруулна.

7.1.6. Бие бүрэлдэхүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгч, биелэлтэд хяналт тавина.

7.1.7. Өндөрт ажиллах үеийн хамгаалах бэхэлгээний цэгийг тогтоон аюулгүй байдалд хяналт тавьж, дайралт болон аврах ажиллагааны зааварчилгааг өгнө.

7.1.8. Аврах тавцан хариуцсан албан тушаалтны нүүр хандсан чиглэлд буюу баруун, зүүн гар тийш, /2,3 алхам гэх мэт/ тушаалаар аврах тавцанг зөөвөрлөх талаар мэдээллийг тухай бүр өгч, хяналт тавина.

7.1.9. Аврах ажиллагаа зохион байгуулж дууссаны дараа мэдээ мэдээллийг зураг, дүрсээр баталгаажуулан илтгэх хуудсаар удирдлагад танилцуулна.

7.2. Аврагч-эмнэлгийн зааварлагчийн үүрэг:

7.2.1. Эмнэлгийн автомашиныг удирдан замын хөдөлгөөний дүрмийг сахиулж, цуваа хоорондын зайг бариулан замын хөдөлгөөнд оролцоно.

7.2.2. Хаягт очиж /нэмэлтээр бүлэг ажиллаагүй тохиолдолд/ аврах тавцанг аврах гэж буй хүний зүг зөөвөрлөхөд алба хаагчдыг удирдана.

7.2.3. Нэрвэгдэгчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагад тээвэрлэх ажиллагааг зохион байгуулна.

7.3. Аврагчийн үүрэг:

7.3.1. Аврагч хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг биед тохируулан өмсөж зүүсэн байна.

7.3.2. Аврах ажиллагааны хамгаалалт бэхэлгээг бүрэн хийж дууссаны дараа ажиллагааг эхлүүлнэ.

7.3.3. Бүлгийн даргын өгсөн үүргийн дагуу заасан чиглэлээс аюулгүй байдлыг ханган өндрөөс үсрэх оролдлого хийж буй иргэнтэй ярилцан тайвшруулах, анхаарал сарниулах ажиллагааг хийнэ.

7.3.4. Шаардлагатай багаж хэрэгсэл болон аврах тавцанг зөөвөрлөх тэдгээрийг ажиллагаанд бэлтгэнэ.

7.4. Аврагч-жолооч, холбоочны үүрэг:

7.4.1. Замын хөдөлгөөний дүрэм, аюулгүй байдлыг хангаж хөдөлгөөнд оролцоно.

7.4.2. Байнгын байрлалаас хаяг хүртэлх хугацаа, автомашин хоорондын зайг баримтлан дуудлага хүлээн авагчид хаягт ирснээ мэдэгдэнэ.

7.4.3. Аврах тавцан болон хоолой дэлгэх талбайг саадгүй болгох, шаардлагатай багаж хэрэгслийг бэлтгэх, хийн баллоныг хариуцан ажиллана.

7.4.4. Бүлгийн даргын мэдээ, мэдээллийг дуудлага хүлээн авагчид тухай бүр дамжуулж холбоог зохион байгуулна.

Найм. Бусад










8.1. Аврах бүлэг ажиллагааны дараа ангийн байрлалд буцаж тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалган засвар үйлчилгээ хийж, дараагийн дуудлагаар үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангана.

8.2. Аврах бүлгийн дарга зохион байгуулсан аврах ажиллагааны талаар дүгнэн хэлэлцэж тэмдэглэл хөтлөн илтгэх хуудасны хамт удирдлагад танилцуулна.

8.3. Өндөр барилга, байгууламжаас аврах ажиллагаа зохион байгуулах үед өндрөөс үсрэх оролдлого хийж буй иргэний дэргэд аман дохиогоор тушаал өгөх, үйл ажиллагааны талаар ярилцахыг хориглоно.




ӨНДРӨӨС БОЛОН НИСДЭГ ТЭРГЭЭР АВРАХ АЖИЛЛАГАА
ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЕИЙН БИЕТ ДОХИО

 <p>1. "Анхаар" дохиог баруун гарыг эгц дээш өргөнө.</p>	 <p>2. "Бэлэн" дохиог баруун гарыг эгц дээш өргөж, цагийн зүүний дагуу эргүүлнэ.</p>
 <p>3. "Суу" дохиог баруун гарыг тохойгоор нугалж, эгц дээрээс доош буулгана.</p>	 <p>4. "Бос" дохиог баруун гарыг мөрний түвшинд тэнийлгэж, доороос эгц дээш өргөнө.</p>
 <p>5. "Дөх" дохиогоор нэрвэгдэгчид ойртох болон холдох хөдөлгөөнийг аажмаар гүйцэтгэх бөгөөд баруун гарыг тохой хэсгээр нугалж урагш хойш хөдөлгөнө.</p>	 <p>6. "Дайр" дохиог хоёр гарыг урдаа хагас тэнийлгэж дотогш хөдөлгөнө.</p>
 <p>7. "Зогс" дохиог аливаа хөдөлгөөнийг хязгаарлах болон зогсооход өгөх бөгөөд зүүн гарыг мөрний түвшинд алдлан хоёр тийш хөдөлгөнө.</p>	
 <p>1. "Агаарт тогтох" дохиог хоёр гарыг мөрний түвшинд алдална.</p>	 <p>2. "Доошил" дохиог хоёр гарыг мөрний түвшинд алдлан гарын алгыг доош нь харуулж гарыг доош хөдөлгөнө.</p>



3. "Дээшил" дохиог хоёр гарыг мөрний түвшинд алдлан гарын алгыг дээш харуулж гарыг дээш нь хөдөлгөнө.



4. "Заасан чиглэлд яв" дохиог явуулах чиглэл рүү хоёр гараа сунган зааж явах чиг рүү гарыг хөдөлгөнө.



5. "Чиглэлээ өөрчил" дохиог явж байгаа чиглэлийг өөрчлөх зүг рүү хоёр гарыг сунган заана.




6. "Над руу яв" дохиог хоёр гарыг тохойгоор нугалан өргөж гарын алгыг хойш нь харуулан гараа цааш нааш нь хөдөлгөнө.



7. "Угтах дохиог" хоёр гарын алгыг тэнийлгэж дээш өргөнө.



8. "Зам талбай чөлөөтэй" дохиог баруун гарыг тохойгоор нугалан өргөж эрхий хурууг гозойлгоно.



9. "Газардах" дохиог хоёр гараа алдлан буух талбай руу харж зогсоно.



10. "Газарт" дохиог хоёр гарыг урдаа сунган зөрүүлэн унжуулна.







11. "Зогс" дохиог гарын алгыг тэнийлгэж хоёр гараа дээш өргөн зөрүүлж хөдөлгөнө.




12. "Хөдөлгүүр унтраа" дохиог баруун гарыг мөрний түвшинд нугалан баруун зүүн тийш хөдөлгөнө.




ӨНДРӨӨС НЭРВЭГДЭГЧ БОЛОН ХҮНИЙГ БУУЛГАХ ДАРААЛАЛ

<p>1. Бэхэлгээний цэгийг нэрвэгдэгч болон хүнд аль болох ойр (босоо тэнхлэгийн дагуу) байрлуулна.</p>	
<p>2. 2 дугаар аврагч, 1 дүгээр аврагчийг нэрвэгдэгч болон иргэн рүү буулгаж, бэхэлгээний цэг дээр буух төхөөрөмжийг суурилуулна.</p>	
<p>3. 1 дүгээр аврагч нэрвэгдэгч рүү ойртож, нэрвэгдэгчийн урд дамрыг суурилуулна.</p>	
<p>4. 1 дүгээр аврагч дамар ашиглан нэрвэгдэгчийг олс руу шилжүүлнэ.</p>	


5. 1 дүгээр аврагч нэрвэгдэгчийн хамгаалалтын олсыг тайлж, 2 дугаар аврагч, 1 дүгээр аврагч болон нэрвэгдэгчийг доош буулгана.




6. Нэрвэгдэгч болон хүнийг хамгаалах олс ашиглан буулгаж болно. Буух үед нэмэлт карабиныг зайлшгүй ашиглана.






7. Аврагч хамгаалах олс ашиглан нэрвэгдэгч болон иргэн рүү бууна.



8. Нэрвэгдэгчийн аюулгүй байдлыг хангахын тулд аврагч хамгаалах олсыг ашиглана. Үүний дараа нэрвэгдэгчийн олсыг тайлна. Аврагч нэрвэгдэгчийн урд талын гогцооноос карабин ашиглан холбоно.



<p>9. Аврагч нэрвэгдэгч болон хүний буух хэрэгслийг ашиглан өөрийн жинг олсруу шилжүүлж, дараа нь буух төхөөрөмжийг салгана.</p>	<p>5. </p> <p>6. </p>
<p>10. Жумар болон карабины тусламжтайгаар бууна.</p>	<p>7. </p>